

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МБСУМАЗТ	Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв
МБС	Мэргэжлийн боловсрол сургалт
БАЗТ	Бүсийн арга зүйн төв
ГОУХАН	Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ,
СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ,
АРГА ЗҮЙН ТӨВ”-ИЙН ЗАХИРАЛ
Ц.БАТДОРЖ ТАНАА

2020.02.27 № 06/627
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв”-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Ц.Батдорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлага, өглөгийг зөв тусгах, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд төсвийн хөрөнгийг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэн тайлагнаж байх талаар зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдрөөс 2020 оны 2 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Грант Торнтон аудит” ХХК-ийн аудитор О.Уянга, туслах аудитор Г.Мөнхзул нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний Аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр №01/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь:

Чадамжид суурилсан үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн ирээдүйд чиглэсэн цогц тогтолцоог бүрдүүлж, Монгол Улсын Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хөгжилд хувь нэмэр оруулна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлага хангасан төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах, мэргэжлийн түвшин тогтоох, зэрэг олгох, хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах;
- Мэргэжлийн байгууллага, нийгэмлэг холбоодтой хамтран ажил, мэргэжил, ур чадварын стандартыг боловсруулах, шинэчлэх, дүгнэлт гаргах, модулийн сан, тестийн сан бүрдүүлэх, баяжуулах, түгээх;
- Чадамжид суурилсан сургалтын үнэлгээний ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, гэрчилгээ олгох мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх;
- Чадамжид суурилсан сургалтын үнэлгээний журмын хэрэгжилтийг хангах, ур чадварын түвшин бүрээр жишиг даалгавар боловсруулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, түгээх;
- Жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн сан хөтлөх, холбогдох байгууллагатай жолоодох эрхийн шалгалтыг хамтран зохион байгуулах;
- Суурь болон холбогдох судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, санал боловсруулан танилцуулах;
- Мэргэжлийн сургалтын сурагчийг, хичээлийн хэрэглэгдэхүүний агуулгад үнэлгээ хийж, дүгнэлт өгөх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд хандив, тусламж авч болох талаар,
- Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын хувь хэмжээ,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хэмжээ

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,668,459.0 мянган төгрөгөөс тооцон 16,684.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийн залруулагдсан дүн 1,703,269.1 мянган төгрөгийн 1 хувиар тооцон 17,032.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 272,411.2 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	56,226.4	34,803.3	(21,423.1)
Урьдчилгаа	4,420.6	4,508.6	88.0
Бараа материал	27,483.4	24,136.1	(3,347.3)
Үндсэн хөрөнгө	1,342,727.5	1,639,821.1	297,093.6
Нийт хөрөнгө	1,430,857.9	1,703,269.1	272,411.2
Өр төлбөр	165.1	10,384.5	10,219.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,430,692.8	1,692,884.6	262,191.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,430,857.9	1,703,269.1	272,411.2

Авлага дансны эхний үлдэгдэл 2018 оны 56,226.4 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага барагдсан, 2019 онд ГОУХАН-ийн төслийн санхүүжилтийн 34,803.3 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлснээс нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны үлдэгдлээс тайланд онд зарцуулагдсанаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд тайлант онд бичиг хэргийн материалыг оны эцэст сургалтын гэрчилгээтэй холбоотой нөөц үүсгэж 19,965.8

мянган төгрөг, аж ахуй 1,519.6 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 740.0 мянган төгрөг, барилгын материал 160.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2,332.2 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 284,630.1 мянган төгрөг, худалдан авсан 20,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь өөрийн орлогын төлөвлөгөө дутуу бүрдүүлснээс сургалтын гэрчилгээний үнийн үлдэгдэл 9,750.0 мянган төгрөгийн төлбөрийг төлөх эх үүсвэргүй болсон, нэр данс зөрүүтэйгээс болоод шилжүүлж чадаагүй 317.9 мянган төгрөг гүйлгээнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,692,884.6 мянган төгрөг болж 262,191.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн эерэг үзүүлэлттэй гарсанаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 273,316.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас нийт зардлын 125,136.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 148,180.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого 32,210.6 мянган төгрөгөөр тасарсан нь 2019 оны 02-р сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан МБС-ын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөс гарсан шийдвэрээр МБСҮМАЗТ, БАЗТ-ийн давхацсан зарим чиг үүрэг тухайлбал “Сургалтын хөтөлбөрийн дүгнэлт гаргах” үйл ажиллагааг 2019 оны 03-р сарын 01-ний өдрөөс тасалбар болгон МБСҮМАЗТ зогсоосноос шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 239,456.9 мянган төгрөг буюу 87.6 хувьтай байгаа нь орлогын төлөвлөгөө 32,210.6 мянган төгрөг буюу 21.7 хувиар тасарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад үндсэн үйл ажиллагааны орлого тасарсантай холбоотойгоор дараах зардлын гүйцэтгэл бүлгийн дүнгээр хэмнэлттэй харагдаж байна. Тухайлбал:

Цалин, НДШ-ийн зардал 18,026.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 466.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 719.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 3,800.2 мянган төгрөгөөр, бусаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 10,094.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 502.7 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардал 250.0 мянган төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарсан байна. Энэ нь ГОУХАН-ээс санхүүжиж нэмэлтийн данснаас зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөрөөс 281,747.8 мянган төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 72,000.0 мянган төгрөгийн нийт 353,747.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 6,679.7 мянган төгрөгийг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 835.0 мянган төгрөгийг, хангамж, бараа материалын зардалд 1,898.5 мянган төгрөгийг, нормативын зардалд 60,797.5 мянга, томилолт, зочны зардалд 15,341.9 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 42,383.3 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 191,008.6 мянган төгрөгийг нийт 318,944.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 34,803.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 17 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 137,028.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 124,747.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,163.1 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, тэг дүнтэй 1 албан шаардлага хүргүүлж, 7,118.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Бараа материалын түүвэр тооллого болон байгууллагын тооллогын бүртгэлд банкны шимтгэлийн зардал болох 13.4 мянган төгрөгийг бараа материал дансны үлдэгдэлд бүртгэсэн нь бараа материалын үлдэгдэл болон санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлант үеийн зардлыг буруу илэрхийлсэн нь байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан

2. Тайлант хугацаанд худалдан авсан 70,900.6 мянган төгрөгийн бичиг хэрэг, барилгын материалыг зохих дансаар нь дамжуулаагүй зардалд шууд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан

3. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 92 дугаар "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Сонгинохайрхан дүүрэгт байрлах байрыг үндсэн хөрөнгөнд хүлээж авч, үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрөхдөө 49,833.3 мянган төгрөгийн элэгдлийн дүнг хасаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан

4. "Ариг менежмент" ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 18-ний өдөр байгуулсан 18/08 тоот гэрээний дагуу шилжүүлсэн 4,000.0 мянган төгрөгийн үйлчилгээний гэрээг 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр гэрээг дүгнэж, ажил үйлчилгээ төлбөр тооцооны үлдэгдэлгүй болсон боловч тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан

5. Цалингийн тооцооллыг шалгаж үзэхэд нийт 159.9 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

6. ГОУХАН төслийн хүрээнд гарсан 21,200.0 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлснөөс ажил олгогчид ногдох болон даатгуулагчаас суутгах 5,003.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцоогүй олгосон байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2-т "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 7,118.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

7. 2019 оны санхүүгийн тайлангаа хуулийн хугацааг 5 хоног хоцроож ирүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “Төсвийн шууд захирагч ..., жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2019 онд Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн "Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үйл ажиллагааны болон зардлын хэмнэлтийг тооцох, зарцуулах, тайлагнах журам"-ыг холбогдох байгууллагаас санал авч хамтран ажиллах шаардлагатай байна. Энэхүү журам батлагдсанаар орлогын төлөвлөгөө бүрэн орох нөхцөл бүрдэхээр байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 32 мэдээллийг хугацаанд нь, 79 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 33 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан буюу зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 12,281.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 17,032.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дансны авлага, өглөгтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Санхүүгийн байдлын тайлангаарх ХХОАТ-ын өглөг татварын тайлангаарх дүнгээс 6,999.1 мянган төгрөг, НДШ-ийн авлага НДШ-ийн тайлангаарх дүнгээс 119.0 мянган төгрөг нийт 7,118.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар хуулийн 20.2.5-д "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Мөн УСНББОУС 1 "Толилуулга"-ын 27-д "*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч, шударгаар илэрхийлэхийг шаарддаг*" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайланд авлага, зөрүүтэй илэрхийлэгдэх,

3.1.3 Өгсөн зөвлөмж: Татвар, нийгмийн даатгалын тайланг зөв илэрхийлж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу анхаарч ажиллана.

3.2 Шилэн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 32 мэдээллийг хугацаанд нь, 79 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 33 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "*Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*", мөн хуулийн 4.1.3-д "*Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Мэдээллийн ил тод байдал алдагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд төсвийн хөрөнгийг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэн тайлагнаж байх талаар зөвлөмж өгөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,130,400.78</u>	<u>59,434,568.45</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	56,226,400.00	34,803,304.76
33300	Татаас, санхүүжилтийн авлага	56,226,400.00	34,803,304.76
34	УРЬДЧИЛГАА	4,420,583.00	508,561.00
34600	Урьдчилж гарсан зардал	4,203,776.00	203,776.00
3471	Урьдчилгаа тооцоо	216,807.00	304,785.00
34713	Цалингийн урьдчилгаа	216,807.00	304,785.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,483,417.78	24,122,702.69
354	Хангамжийн материал	27,483,417.78	24,122,702.69
35410	Бичиг хэргийн материал	20,901,108.00	16,447,261.00
35420	Аж ахуйн материал	00.00	621,690.00
35430	Сэлбэг хэрэгсэл	341,000.00	341,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	160,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,241,309.78	6,552,751.69
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,342,727,521.88</u>	<u>1,589,987,810.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,342,727,521.88	1,589,987,810.42
392	Биет хөрөнгө	1,342,330,299.16	1,589,883,920.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,114,098,075.21	1,413,098,075.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-37,510,970.52	-124,517,612.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,633,000.00	74,096,480.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,828,472.16	-36,715,143.75
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	165,943,700.82	185,943,700.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,474,924.33	-16,970,293.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,782,769.66	98,782,769.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,312,879.52	-3,834,055.10
393	Биет бус хөрөнгө	397,222.72	103,889.44
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-482,777.28	-776,110.56
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,430,857,922.66</u>	<u>1,649,422,378.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>165,099.43</u>	<u>10,384,528.58</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	165,099.43	10,384,528.58
413	Өглөг	165,099.43	10,384,528.58
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	165,099.43	126,578.58
4136	Бусад өглөг	00.00	10,257,950.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	10,257,950.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,430,692,823.23</u>	<u>1,639,037,850.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,430,692,823.23	1,639,037,850.29

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,944,100.00	8,944,100.00
51101	Өмч: - төрийн	8,944,100.00	8,944,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,421,748,723.23	1,630,093,750.29
51210	Өмнөх үеийн үр дүн	947,553,882.68	1,421,748,723.23
51220	Тайлант үеийн үр дүн	474,194,840.55	208,345,027.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,430,857,922.66</u>	<u>1,649,422,378.87</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	758,149,055.47	823,257,766.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	647,016,455.47	400,599,776.00
120	Нийтлэг татварын бус орлого	647,016,455.47	400,599,776.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	647,016,455.47	400,599,776.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,071,000.00	115,969,630.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	77,226,400.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	441,719,055.47	284,630,146.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	111,132,600.00	422,657,990.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,132,600.00	125,136,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,132,600.00	125,136,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	297,521,390.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	225,521,390.00
